НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0066
Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809
E-mail: contact@ub-procurement.mn
http://www.ub-procurement.mn

2020.05.11 № 02/896

танай ____________ -ны № ____________ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зарласан НХААГ-20/0072 дугаартай Хог тээврийн автомашин /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 8, 10, 20, 23, 28 дугаар хороо/ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс техникийн тодорхойлолттой холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА Э.БОЛОРМАА

1159571148

**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жигжиджавын гудамж 9, Хангарди ордон,
Утас/Факс: (976-11) 31 53 47, И-мэйл: ubzaa@ubservice.mn,
Вэбсайт: www.ubservice.mn

2020.05.06 № 01/1569

танай 2020.05.04-ны № 02/733 -т

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/353 дугаар захирамжаар батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 16 дугаар жагсаалтад заасан хог тээврийн авто машин нийлүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай техникийн тодорхойлолтыг боловсруулан 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 07/982 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Тус техникийн тодорхойлолт нь хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаандаа ашиглаж буй Hyundai HD170 маркийн хог тээврийн задгай тэвштэй авто машины техникийн тодорхойлолттой дүйцүүлсэн бөгөөд түүнээс багагүй гэсэн үзүүлэлтийг тусгасан болно.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ГАНТӨМӨР

C:\Users\Gantuya\Desktop\УЖ 12\doc 2020\A-5doc.docx

1110301247